



**“Хүлэмжийн аж ахуйг хөгжүүлэх” хөтөлбөр**  
**Нэг. Нийтлэг үндэслэл**

1.1. Монгол улсын Их Хурлын 2016 оны 45 дугаар тогтоолоор батлагдсан Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.44-т “өвөл, зуны хүлэмжийн цогцолбор аж ахуйг хөгжүүлж, хот суурины хүн амыг шинэ ургацын ногоогоор тогтвортой хангана”, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын тогтвортой хөгжлийг хангах зорилгоор “Органик хүнсний тухай” хууль, “Эрүүл хүнс-Эрүүл монгол хүн” үндэсний хөтөлбөр, Засгийн газрын 2017 оны 278 тогтоолоор батлагдсан “Хүнсний ногоо” үндэсний хөтөлбөр, 2017 оны 223 тогтоолоор батлагдсан “Жимс, жимсгэнэ” үндэсний хөтөлбөр, “Атрын 3 дугаар аян”-ны хүрээнд хүнсний ногоо, жимс жимсгэний нэр төрөл үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, Ховд аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн зорилт, аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр зэрэг бодлогын баримт бичгүүдийг үндэслэв.

1.2. Тус хөтөлбөр нь Ховд аймагт амьдарч буй 88,0 мянга гаруй иргэдийг экологийн цэвэр, шинэ жимс жимсгэнэ, хүнсний ногоогоор хангахад чиглэсэн үйл ажиллагааг төлөвлөсөн аймаг орон нутгийн хэмжээний төрийн бодлогын баримт бичиг юм.

**Хоёр. Хэрэгцээ шаардлага**

2.1. Аймгийн хэмжээнд хүнсний ногоо тариалж байгаа иргэн, аж ахуйн нэгжид 3186.6 м<sup>2</sup> нийлэг хальсан хүлэмж байгаа бөгөөд үүнээс 50 %”ийг нь огт ашиглахгүй байна. Хүлэмжийн тариалалт эрхэлж буй иргэн, аж ахуйн нэгж байгаа боловч энэ нь улирлын чанартай, дадлага туршлага муутай, ижил хугацаанд нэг төрлийн таримлыг их хэмжээгээр хураан авдаг тул үнэ нь тогтворгүй, шинэ ургацын ногоо болон үйлдвэрийн аргаар боловсруулсан ногоог хүргэх худалдаа, үйлчилгээ, хадгалалтын сүлжээ байхгүйгээс хүлэмжийн аж ахуй өсөж хөгжихгүй байна.

Хүний биед нэмэлт эрдэс, амин дэм шаардагддаг 11- 6 саруудад хүнсний ногооны хангамж эрс муудаж, үнэ өсдөг тул, гарал үүсэл нь тодорхойгүй хүнсний ногоог импортлон хэрэглэсээр байгаа нь хүн амыг эрүүл, аюулгүй хүнсээр хангах асуудал алдагдахад хүрээд байна.

2.2. Улаан лооль, өргөст хэмх, чинжүү гэх мэт ногоог 1 хүний хэрэгцээнд жилд 40 кг-аар тооцож үзэхэд аймгийн хэмжээнд дунджаар 3200 тн шинэ нэр төрлийн хүнсний ногоо үйлдвэрлэх шаардлагатай болж байна.

2.3. Өнөөгийн байдлаар хүнсний нарийн ногооны хангамжийг өрхийн тариаланд тулгуурлан хөгжүүлэх нь өртөг зардал багатай, төрийн дэмжлэг, туслалцаа харьцангуй бага шаарддаг боловч бүтээмж муу, шинжлэх ухаан, технологийн ололтыг нэвтрүүлэх боломж хязгаарлагдмал байдаг. Тиймээс нийт хүн амын хэрэгцээг дан ганц өрхийн тариалангаар хангах боломжгүй учир хот суурины ойролцоо хүнсний ногоо, жимс, жимсгэнэ тариалах, төрөлжсөн хүлэмжийн аж ахуйг байгуулж, Агропарк, хоршооллын тариаланг дэмжих явдал илүү үр дүнтэй болохыг өнгөрсөн жилүүдийн үйл ажиллагаа харуулж байна.

Энэхүү нөхцөл шаардлагыг үндэслэн, өрхийн хүлэмжийн аж ахуй эрхлэгчдэд мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллахаас гадна ногооны төрөлжсөн хүлэмжийн цогцолбор аж ахуйг кластериар хөгжүүлэх, хүнсний нарийн ногоо, жимс жимсгэний тариалалтыг нэмэгдүүлэх, шинэ нэр төрлийн таримлыг зах зээлд гаргах, ногооны үрийн аж ахуйг бэхжүүлэх, борлуулалтыг дэмжих замаар дотоодын үйлдвэрлэлийг өсгөх зорилгоор "Хүлэмжийн аж ахуйг хөгжүүлэх" дэд хөтөлбөрийг боловсруулав.

#### **Гурав. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх зарчим**

Хөтөлбөрийг хэрэгжүүлэхдээ дараах зарчмыг баримтална:

3.1. Байгаль орчинд ээлтэй аргаар тариалан эрхэлж, органик бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд анхаарах, импортоор орж буй хүнсний ногоо, жимс жимсгэний хэмжээг бууруулах, дотооддоо үйлдвэрлэхийг түлхүү дэмжих

3.2. Орчин үеийн техник, технологи, шинжлэх ухааны дэвшилд суурилсан байх

3.3. Хувийн хэвшилтэй зардал хуваах зарчмаар тэдний санал, санаачлагд тулгуурлах

3.4. Аймгийн хүн амын хэрэглээний хүлэмжийн таримлын нийлүүлэлтийг жилийн турш тогтвортой, үнийн хэлбэлзэл багатай болгох.

#### **Дөрөв. Дэд хөтөлбөрийн зорилго**

Энэхүү хөтөлбөрийн зорилго нь өрхийн тариалан эрхлэгч болон төрөлжсөн хуулийн этгээдийг хүлэмж, түүний тоног төхөөрөмж, үр суулгацаар ханган, дэмжих замаар нарийн ногоо, жимс жимсгэний үйлдвэрлэлийг нэмэгдүүлж, шинэ нэр төрлийн бүтээгдэхүүнээр дотоодын хэрэгцээг хангахад оршино.

#### **Тав. Зорилтууд**

5.1. Хөтөлбөрийн хүрээнд хүлэмжийн аж ахуй эрхлэхийг хүссэн туршлагатай тариаланч, иргэн, аж ахуйн нэгжүүдийг нэгтгэн хүлэмжийн цогцолбор аж ахуйг байгуулах /кластериар хөгжүүлэх/

5.2 Хүлэмжид тариалах ургамлын нэр төрлийг нэмэгдүүлж, ургацын чанарыг сайжруулах, нэгжээс авах ургацыг нэмэгдүүлэх, үнийг тогтворжуулах

5.3. Хүлэмжийн аж ахуйн сургалт, судалгааны төв байгуулах /Хөдөө аж ахуйн газрын талбайг түшиглэн хүлэмжийн аж ахуй байгуулж сургалт зохион байгуулах,

шинэ төрлийн таримлын туршилт судалгаа хийх/, хүлэмжийн тариалан эрхлэгчдийг дэмжих, сургах, туршлага солилцох гэх мэт дадлагажуулах, чадавхыг сайжруулах

5.4. Хүлэмжийн тариалалтад шаардагдах техник тоног төхөөрөмж, үр, бордоо, суулгацыг нийлүүлэхэд дэмжлэг үзүүлэх

5.5. Хяналтын системийг сайжруулах

5.6. Борлуулалтын сүлжээг хөгжүүлэх, ард иргэдийн нарийн ногооны хэрэгцээг хангах

### **Зургаа. Хэрэгжүүлэх арга хэмжээ**

6.1. Хөтөлбөрийн хүрээнд хүлэмжийн аж ахуй эрхлэхийг хүссэн туршлагатай тариаланч, иргэн, аж ахуйн нэгжүүдийг нэгтгэн хүлэмжийн цогцолбор аж ахуйг байгуулах /кластериар хөгжүүлэх/

6.1.1. Өрхийн тариалан эрхлэгчид болон аж ахуйн нэгжүүд сайн дураараа нэгдэх, хуулийн этгээд байгуулах, нэгдсэн байдлаар техник тоног төхөөрөмжийг худалдан авахад нь санхүү зээл, хөрөнгө оруулалтын дэмжлэг үзүүлэх замаар хүлэмжийн цогцолбор аж ахуйг хөгжүүлэх

6.1.2. Хүлэмжийн цогцолбор барих газрыг олгох, дэд бүтцийг шийдэх, барилга байгууламжийн зураг төсөв боловсруулах, худаг гаргах, хашаа барих, агуулах барих, сүлжээ дэлгүүр, лаборатори байгуулах зэрэг хөрөнгө оруулалт ихээр шаардагдах ажлуудын зардлыг тооцож холбогдох дээд шатны газарт ажлын саналыг хүргүүлэх, төсөл хөтөлбөрүүдэд хандах замаар шийдвэрлүүлэх

6.1.3. Нийлэг хальсан хүлэмжийн нийлэг цаасны хангамжийг нэмэгдүүлж иргэн, аж ахуйн нэгжид хөнгөлөлттэй нөхцөлөөр олгож ашиглагдахгүй байгаа хүлэмжүүдийг ашиглуулах

6.1.4. Хүлэмжийн аж ахуй эрхлэхийг хүссэн тариаланчийг /20 хүртэл/ шалгаруулж хүлэмж, түүний тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, усалгааны системээр дэмжих тодорхой нөхцөлтэй, эргэн төлөлттэйгөөр гарааны бизнесийг эхлүүлэх, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх

6.1.5. Сумдад 1 - 2 хүлэмж шинээр байгуулах ажлыг сум орон нутагтай хамтран шийдвэрлэх

6.1.6. Жил бүр зуны хүлэмжийн тоо хэмжээг 1000м<sup>2</sup>, өвлийн хүлэмжийг 100м<sup>2</sup> – аар нэмэгдүүлэх

6.1.7. Хүлэмжийн цогцолбор аж ахуйг зохион байгуулахад мэргэжлийн боловсон хүчин агрономич, шинжээч, борлуулалтын менежер ажиллуулах, тэдний цалин болон ажлын байрны зардлыг аж ахуйн нэгжээр хариуцуулах

6.2. Хүлэмжид тариалах ургамлын нэр төрлийг нэмэгдүүлж, ургацын чанарыг сайжруулах, нэгжээс авах ургацыг нэмэгдүүлэх, үнийг тогтворжуулах

6.2.1. Хүлэмжид тариалах боломжтой болон ашигтай шинэ таримлыг судалгаа хийсний үндсэн дээр тариалах, нутагшуулах, үйлдвэрлэлд нэвтрүүлэх ажлыг зохион байгуулах

6.2.2. Чацаргана, үхрийн нүд, алим, чавга, интоор, гүзээлзгэнэ гэх мэт бусад жимс жимсгэний сортын суулгац бэлтгэх, хүлэмжийн эх цэцэрлэг /жимс жимсгэний плантаци, агропарк/ байгуулахад дэмжлэг үзүүлэх, тэдгээрийн бэлдсэн суулгац, үр жимсийг тариалах аж ахуйн нэгж, иргэдэд тодорхой хувийн хөнгөлөлттэй үнээр, урт хугацаагаар зээлээр олгох

6.2.3. Талбайн түүх хөтлөх, ашиглалтыг сайжруулах, экологийн цэвэр бүтээгдэхүүн үйлдвэрлэх талаар заавар, зөвлөмжөөр хангах, орчин үеийн шинэ технологи нэвтрүүлэх,

6.2.4. Шинэ ногооны хангамжийг тасралтгүй гаргахаар төлөвлөлт хийж тариалалтыг зохион байгуулалттай хийх.

6.3. Хүлэмжийн аж ахуйн сургалт, судалгааны төв байгуулах /Хөдөө аж ахуйн газрын талбайг түшиглэн хүлэмжийн аж ахуй байгуулж сургалт зохион байгуулах, шинэ төрлийн таримлын туршилт судалгаа хийх/, хүлэмжийн тариалан эрхлэгчдийг дэмжих, сургах, туршлага солилцох гэх мэт дадлагажуулах, чадавхыг сайжруулах

6.3.1. Хүлэмжийн аж ахуй эрхлэгчдийн мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх, мэргэжилтэй ажилчин бэлтгэх, мэдээллээр хангах мэргэжлийн багш сургагчаар хичээл заалгах замаар хүний нөөцийн чадавхыг сайжруулах,

6.3.2. Сургалт, судалгааны төв байгуулах /сургалт зохион байгуулах, шинэ төрлийн таримлын туршилт судалгаа хийх/

6.3.3. Бусад аймаг болон гадаадад туршлага судлуулах, бүс, улсын хэмжээний болон олон улсын үзэсгэлэн худалдаа, арга хэмжээнүүдэд оролцуулах

6.4. Хүлэмжийн тариалалтад шаардагдах техник тоног төхөөрөмж, үр, бордоо, суулгацыг нийлүүлэхэд дэмжлэг үзүүлэх

6.4.1. Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн яамнаас хөнгөлөлттэй үнээр олгогдож буй шинэ техник, мотоблок, мотоблокинд сольж угсардаг үрлэгч, арчлах, соортлох, хураах техникээр хангах, ялгаж дугаарлах, савлах төхөөрөмж, гар багажууд нийлүүлэхэд дэмжлэг үзүүлэх, шинэ технологи нэвтрүүлэх,

6.4.2. Хүлэмжид тариалагдах үр, суулгац, бордоо, био бэлдмэлүүдийг төсөл хөтөлбөрийн дэмжлэгээр олгуулах

6.5. Хяналтын системийг сайжруулах

6.5.1. Органик хүнсний ногоог батламжлан гэрчилгээ олгох итгэмжлэгдсэн лабораторийг төр, хувийн хэвшилд тулгуурлан байгуулах

6.5.2. Дотоодын болон хөндлөнгийн хяналт үнэлгээг хийлгэж, арга зүй зөвлөмжөөр хангах

6.5.3. Статистикийн мэдээлэлд хүлэмжид таригдсан ногооны нэр төрөл, тоо хэмжээг оруулж, олон нийтэд түгээж мэдээлж байх

6.6. Борлуулалтын сүлжээг хөгжүүлэх, ард иргэдийн нарийн ногооны хэрэгцээг хангах

6.6.1. Хүлэмжийн цогцолбор аж ахуйн хүрээнд нэрийн барааны дэлгүүр ажиллуулах

6.6.2. Аймгийн төв болон сумуудад сүлжээ дэлгүүрүүдийг бий болгох, бараа түгээлтийг тасралтгүй явуулах

6.6.3. Сав, баглаа боодол, нэр, шошгыг хэрэглэгчийн хэрэглээнд нийцүүлэх

6.6.4. Бүх сум, байгууллагуудын хүн амын хүнсний ногоо, жимс жимсгэний хэрэглээг нэмэгдүүлэх, борлуулалтыг төрийн худалдан авалт /боловсрол, эрүүл мэнд, батлан хамгаалах, хууль сахиулах, уул уурхай/-аар худалдан авалтыг дэмжүүлэх бодлого, зохицуулалтын арга хэмжээ авах, худалдаа, үйлчилгээ, аялал жуулчлал, зоогийн газруудад сурталчлах

6.6.5. Хүлэмжид тариалагдсан хүнсний ногоо, жимс, жимсгэний борлуулалтыг дэмжих, бүтээгдэхүүнийг сурталчлах зорилгоор “Алтан намар” ургацын баяр, “Хаврын баяр” зэрэг үзэсгэлэн худалдааг аймагт тогтмол зохион байгуулах .

#### **Долоо. Хөтөлбөр хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалт**

7.1. Хөтөлбөрийн хэрэгжилтийг зохион байгуулах, зохицуулах, хяналт тавих үүрэг бүхий аймгийн салбар зөвлөл ажиллана. Салбар зөвлөлийн бүрэлдэхүүнд ХОХБТХ-ийн дарга, мэргэжилтэн, ХХААГ, Төрийн бус байгууллага, агрономич, тариаланчдын төлөөлөл оролцоно.

7.2. Хөтөлбөр хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх төсөл арга хэмжээ, хөрөнгийг жил бүрийн аймгийн үндсэн чиглэл, төсөвт тусгахыг салбар зөвлөл хариуцан батлуулах, бусад эх үүсвэрээс хөрөнгө олж татан төвлөрүүлэх, хуваарилсан хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулж, дүнг иргэдийн Төлөөлөгчдийн Хурал болон Засаг даргын зөвлөл, холбогдох газруудад тайлагнана.

#### **Найм. Хөтөлбөрийн санхүүжилт**

“Хүлэмжийн аж ахуйг хөгжүүлэх” хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд дараах хөрөнгийн эх үүсвэрийг ашиглана.

Үүнд: Иргэн, хуулийн этгээдийн өөрийн хөрөнгө, Улсын болон орон нутгийн төсөв, Тариалан эрхлэлтийг дэмжих сан, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан, Банкны зээл, Жижиг дунд үйлдвэрлэлийн зээл, Сум хөгжүүлэх сан, Гадаад орон, олон улсын байгууллагын буцалтгүй тусламж, дэмжлэг, хөнгөлөлттэй зээл зэрэг болно.

#### **Ес. Хөтөлбөрийн үр дүн шалгуур үзүүлэлт**

9.1. Зуны хүлэмжийн тоо

9.2. Өвлийн хүлэмжийн тоо

- 9.3. Зохион байгуулагдах арга хэмжээний тоо
- 9.4. Ажлын байр
- 9.5. Хүлэмжид тариалагдсан таримлын ургацын хэмжээ
- 9.6. Үнэ тогтворжсон байдал
- 9.7. Хүлэмжийн аж ахуй эрхлэгчдийг сургалтанд хамруулсан байдал
- 9.8. Бордоо, ургамал хамгаалах бэлдмэлийн зүй зохистой хэрэглээ,
- 9.9. Хүлэмжийн таримлын хэрэглээний байдал хувиар

### Шалгуур үзүүлэлт

№	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин 2018	Хүрэх түвшин			
			2019	2020	2021	2022
1	Жилд байгуулах зуны хүлэмжийн хэмжээ	3186,6 м <sup>2</sup>	1000 м <sup>2</sup>	1000 м <sup>2</sup>	1000 м <sup>2</sup>	1000 м <sup>2</sup>
2	Жилд байгуулах өвлийн хүлэмжийн хэмжээ	0	100 м <sup>2</sup>	100 м <sup>2</sup>	100 м <sup>2</sup>	100 м <sup>2</sup>
3	Шинээр гарсан ажлын байрны тоо	-	15	15	15	15
4	Дотооддоо үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний хэмжээ	60 тн	80 тн	150 тн	200 тн	300 тн
5	Сургалтанд хамрагдах тариаланчдын тоо	10-15	50	60	60	60
6	Үнэ тогтворжсон байдал /улаан лооль, хэмх, чинжүү, навчит ногоо/	Улаан лооль -300 тн Хэмх- 295 тн Чинжүү- 3 тн Навчит ногоо- 200 кг	600	1000	1500	2000
7	Ард иргэдийн шинэ ногооны хэрэглээ /хувиар/	18%	20%	50%	60%	65%

### Арав. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх хугацаа

10.1. Хөтөлбөрийг 2019 - 2022 онд хэрэгжүүлнэ

#### Арван нэг. Хөтөлбөрийн хяналт, шинжилгээ, үнэлгээ

11.1. Аймгийн салбар зөвлөл хөтөлбөрийн хэрэгжилтэд жил бүр хяналт - шинжилгээ, үнэлгээ хийнэ.

11.2. Хяналт - шинжилгээ, үнэлгээний явцын болон эцсийн дүгнэлт, зөвлөмжид үндэслэн хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлэх, нэмэлт, өөрчлөлт оруулах болон шаардлагатай бусад арга хэмжээ авах ажлыг зохион байгуулна.

### Хүлэмжид тариалж болох таримлын нэр төрөл, ургац, үнэлгээ

№	Таримлын нэр	1м <sup>2</sup> –аас авах ургац /кг/	Зах зээлийн үнэ /1 кг/	120 кв.м талбайн ургац /кг/	Бүгд үнэ/төгрөг/
Хүнсний ногоо					
1	Өргөст хэмх	6	4000	720	2,880,000
2	Улаан лооль	8	4000	960	3,840,000

3	Улаан лооль	12	3000	1440	4,320,000
4	Амтат чинжүү	7	3500	840	2,940,000
5	Гашуун чинжүү	4	3500	480	1,680,000
6	Цэцэгт байцай	10	4000	1200	4,800,000
7	Урт байцай	6	1300	720	936,000
8	Салатны байцай	3	3500	360	1,260,000
9	Брокли	3	4000	360	1,440,000
10	Шанцай	3	3500	360	1,260,000
11	Вандуй	2	3000	240	720,000
12	Шош	2	2500	240	600,000
13	Цагаан лууван	3	1500	360	540,000
14	Цагаан гаа	3	6000	360	2,160,000
15	Сармисны гол	4	3500	480	1,680,000
16	Бууцай	4	3500	480	1,680,000
17	Юуцай	3	3500	360	1,260,000
18	Жууцай	5	3500	600	2,100,000
19	Урт сонгино	5	1000	600	600,000
20	Цэс	4	4000	480	1,920,000
21	Яншуй	3	5000	360	1,800,000
Жимс, жимсгэнэ					
25	Гүзээлзгэнэ	6	30000	720	21,600,000
26	Бөөрөлзгөнө	6	25000	720	18,000,000
27	Үхрийн нүд	6	6000	720	4,320,000
28	Улаалзгана	6	6000	720	4,320,000
29	Чавга	6	6000	720	4,320,000
30	Алим	6	5000	720	3,600,000
31	Модны үрслэг	250	500 - 1500	25000	12,500,000

--oOo--

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2019 оны  
21 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралт



“ХҮЛЭМЖИЙН АЖ АХУЙГ ХӨГЖҮҮЛЭХ” ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ  
АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

д/д	Хийж гүйцэтгэх ажлын үндсэн чиглэл	Хүрэх үр дүн	Хугацаа				Төсөв /сая.төг/	Хамрах хүрээ	Хариуцах эзэн
			2019	2020	2021	2022			
Зорилт 1 Хүлэмжийн аж ахуйг хөгжүүлэх хөтөлбөрийн хүрээнд хүлэмжийн аж ахуй эрхлэхийг хүссэн туршлагатай тариаланч, иргэн, аж ахуйн нэгжүүдийг нэгтгэн хүлэмжийн цогцолбор аж ахуйг байгуулах /кластериар хөгжүүлэх/									
1.1	Өрхийн тариалан эрхлэгчид болон аж ахуйн нэгжүүд сайн дураараа нэгдэх, хуулийн этгээд байгуулах, нэгдсэн байдлаар техник тоног төхөөрөмжийг худалдан авахад нь санхүү зээл, хөрөнгө оруулалтын дэмжлэг үзүүлэх замаар хүлэмжийн цогцолбор аж ахуйг хөгжүүлэх.	Нэгдсэн зохион байгуулалтад орсноор төр, хувийн хэвшлийн уялдаа холбоо сайжирч, хүлэмжийн аж ахуйг хөгжүүлж загвар аж ахуй бий болно.	+	+	+	+	126,0	Төр, хувийн хэвшил	Аймаг сумын ЗДТГ, ХХААГ, сумдын ХАА-н тасаг, аж ахуйн нэгж, иргэд
1.2	Хүлэмжийн цогцолбор барих газрыг олгох, дэд бүтцийг шийдэх, барилга байгууламжийн зураг төсөв боловсруулах, худаг гаргах, хашаа барих, агуулах барих, сүлжээ дэлгүүр, лаборатори байгуулах зэрэг хөрөнгө оруулалт ихээр шаардагдах ажлуудын зардлыг тооцож холбогдох дээд шатны газарт ажлын саналыг хүргүүлэх, төсөл хөтөлбөрүүдэд хандах замаар шийдвэрлүүлэх.	Хүлэмжийн аж ахуйн цогцолбор бий болсноор ажлын байр нэмэгдэж, хүнсний ногооны хэрэглээ өснө.	+	+	+	+	20,0	ЗДТГ, ХХААГ, Аж ахуйн нэгж, тариаланч, ногоочид	ЗДТГ, ХХААГ
1.3	Нийлэг хальсан хүлэмжийн нийлэг цаасны хангамжийг нэмэгдүүлж иргэн, аж ахуйн нэгжид хөнгөлөлттэй нөхцөлөөр олгож ашиглагдахгүй байгаа хүлэмжүүдийг ашиглуулах.	Иргэд хүлэмжийн аж ахуй эрхлэх боломж бүрдэнэ.	+	+	+	+	9,0	Хүлэмжийн аж ахуйн эрхлэгчид	ЗДТГ, ХХААГ
1.4	Сумдад 1 – 2 хүлэмж шинээр байгуулах ажлыг сум орон нутагтай хамтран зохион байгуулж, жил бүр зуны хүлэмжийн тоо хэмжээг 1000м2, өвлийн хүлэмжийг 100м2 – аар нэмэгдүүлэх.	Зуны хүлэмж 1000 м2, өвлийн хүлэмж 100 м2 -аар нэмэгдүүлсэн байна.	+	+	+	+	136,0	ЗДТГ, ХХААГ, Аж ахуйн нэгж, тариаланч, ногоочид	ЗДТГ, ХХААГ, Сумын ЗДТГ, ХАА-н тасаг



1.5	Хүлэмжийн цогцолбор аж ахуйг зохион байгуулахад мэргэжлийн боловсон хүчин агрономич, шинжээч, борлуулалтын менежер ажиллуулах, тэдний цалин болон ажлын байрны зардлыг ААН-ээр хариуцуулах.	Боловсон хүчний хангамж сайжирч, чадавхажсан байна	+	+	+	+	38,4	ЗДТГ, ХХААГ, Хөгжил политехник коллеж, Аж ахуйн нэгж, тариаланч, ногоочид	ЗДТГ, ХХААГ, Хөгжил политехник коллеж
Зорилт 2. Хүлэмжид тариалах ургамлын нэр төрлийг нэмэгдүүлэн, ургацын чанарыг сайжруулах, нэгжээс авах ургацыг нэмэгдүүлэх, үнийг тогтворжуулах									
2.1	Хүлэмжид тариалах боломжтой болон ашигтай шинэ таримлыг судалгаа хийсний үндсэн дээр тариалах, нутагшуулах, үйлдвэрлэлд нэвтрүүлэх ажлыг зохион байгуулах.	Таримлын төрөл нэмэгдэж, үйлдвэрлэлд нэвтрүүлж эхэлсэн байна.	+	+	+	+	8,0	ХХААГ, Хөгжил политехник коллеж, Аж ахуйн нэгж, тариаланч, ногоочид	ХХААГ, Хөгжил политехник коллеж, Мэргэжлийн холбоодууд
2.2	Талбайн түүх хөтлөх, ашиглалтыг сайжруулах, экологийн цэвэр бүтээгдэхүүн үйлдвэрлэх талаар заавар, зөвлөмжөөр хангах, орчин үеийн шинэ технологи нэвтрүүлэх.	Хүнсний ногоо, жимс, жимсгэний талбайн түүх хөтөлж, шинэ технологийн гарын авлага, зөвлөмжөөр хангагдсан байна.	+	+	+	+	20,0	МХГ, ХХААГ, Хөгжил политехник коллеж, Аж ахуйн нэгж, тариаланчид,	МХГ, ХХААГ, Аж ахуйн нэгж, тариаланч, ногоочид
2.3	Шинэ ногооны хангамжийг тасралтгүй гаргахаар төлөвлөлт хийж тариалалтыг зохион байгуулалттай хийх.	Иргэдийн шинэ төрлийн ногооны хангамж сайжирч, тариалалт зохион байгуулалттай хийгдэнэ.	+	+	+	+	6,0	Аймгийн нийт иргэд	ХХААГ, Аж ахуй нэгж, ногоочид
Зорилт 3. Хүлэмжийн аж ахуйн сургалт, судалгааны төв байгуулах /Хөдөө аж ахуйн газрын талбайг түшиглэн хүлэмжийн аж ахуй байгуулж сургалт зохион байгуулах, шинэ төрлийн таримлын туршилт судалгаа хийх/, хүлэмжийн тариалан эрхлэгчдийг дэмжих, сургах, туршлага солилцох гэх мэт дадлагажуулах, чадавхыг сайжруулах									
3.1	Хүлэмжийн аж ахуй эрхлэгчдийн мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх, мэргэжилтэй ажилчин бэлтгэх, мэдээллээр хангах мэргэжлийн багш сургагчаар хичээл заалгах замаар хүний нөөцийн чадавхыг сайжруулах,	Сургалт, судалгааны ажлыг мэргэжлийн байгууллагуудтай хамтран хэрэгжүүлж ногоочдыг чадавхжуулна.	+	+	+	+	14,0	Хөтөлбөрт хамрагдсан тариаланч иргэд	ХХААГ, Хөгжил Политехник коллеж, аж ахуйн нэгжүүд, ногоочид
3.2	Сургалт, судалгааны төв байгуулах /сургалт зохион байгуулах, шинэ төрлийн таримлын туршилт судалгаа хийх/	Шинэ төрлийн таримлын судалгаа хийгдэж, төрөл нэмэгдэнэ.	+	+	+	+	24,0	ЗДТГ, ХХААГ, Хөгжил политехник коллеж, Аж ахуйн нэгж, тариаланчид,	ЗДТГ, ХХААГ, Аж ахуйн нэгжүүд, ногоочид
3.3	Бусад аймаг болон гадаадад туршлага судлуулах, бүс, улсын хэмжээний болон олон улсын үзэсгэлэн худалдаа, арга	Хүлэмжийн аж ахуй эрхлэгчид туршлага судалж, түгээн	+	+	+	+	15,0	ЗДТГ, ХХААГ, аж ахуйн нэгж,	ЗДТГ, ХХААГ, Аж ахуйн нэгжүүд,

	хэмжээнүүдэд оролцуулах	дэлгэрүүлнэ. Шинэ төрлийн брэнд бүтэгдэхүүний төрлийг нэмэгдүүлэх.							тариаланч, ногоочид	ногоочид
Зорилт 4. Хүлэмжийн тариалалтад шаардагдах техник тоног төхөөрөмж, үр, бордоо, суулгацыг нийлүүлэхэд дэмжлэг үзүүлэх										
4.1	ХХААХҮЯ-аас хөнгөлөлттэй үнээр олгогдож буй шинэ техник, мотоблок, мотоблокинд сольж угсардаг үрлэгч, арчлах, соортлох, хураах техникээр хангах, ялгаж дугаарлах, савлах төхөөрөмж, гар багажууд нийлүүлэхэд дэмжлэг үзүүлэх, шинэ технологи нэвтрүүлэх,	Аж ахуй эрхлэгчид тоног төхөөрөмжийн дэмжлэг авч, шинэ технологиудыг нэвтрүүлэх.	+	+	+	+	29,6		ХХААХҮЯ, ХХААГ, ногоочид	ХХААХҮЯ, ХХААГ
4.2	Хүлэмжид тариалагдах үр, суулгац, бордоо, био бэлдмэлүүдийг төсөл хөтөлбөрийн дэмжлэгээр олгуулах	Үр, бордоо, бусад материалуудаар хангах.	+	+	+	+	40,0		ХХААХҮЯ, ХХААГ, Төсөл, хөтөлбөрүүд	ХХААГ
Зорилт 5. Хяналтын системийг сайжруулах										
5.1	Органик хүнсний ногоог батламжлан гэрчилгээ олгох итгэмжлэгдсэн лабораторийг төр, хувийн хэвшилд тулгуурлан байгуулах	Органик хүнсний ногоо тариалагчдын тоо нэмэгдэж, ногоочид гэрчилгээжсэн байна.	+	+	+	+	250,0		Аймгийн МХГ, ХХААГ, Стандартчлал хэмжил зүйн хэлтэс	МХГ, ХХААГ, СХЗХ
5.2	Дотоодын болон хөндлөнгийн хяналт үнэлгээг хийлгэж, арга зүй зөвлөмжөөр хангах	Хөтөлбөрийн хэрэгжилтэд хөндлөнгийн болон дотоодын аудитын хяналт үнэлгээ хийлгэдэг болсон байна.	+	+	+	+	8,0		ХХААГ, Төсөл хөтөлбөрүүд	ХХААГ, сумын ХАА-н тасгаг
5.3	Статистикийн мэдээлэлд хүлэмжид таригдсан ногооны нэр төрөл, тоо хэмжээг оруулж, олон нийтэд түгээж мэдээлж байх	Таримлын нэр төрөл нэмэгдэж, олон нийтэд түгээн дэлгэрүүлнэ.	+	+	+	+	8,0		Аймгийн Статистикийн хэлтэс, ХХААГ	ХХААГ, сумын ХАА-н тасгаг
Зорилт 6. Борлуулалтын сүлжээг хөгжүүлэх, ард иргэдийн нарийн ногооны хэрэгцээг хангах										
6.2	Аймгийн төв болон сумуудад хүлэмжийн цогцолбор аж ахуйн хүрээнд сүлжээ дэлгүүрүүдийг бий болгох, бараа түгээлтийг тасралтгүй явуулах	Иргэдийг шинэ ургацын ногоогоор тасралтгүй хангах	+	+	+	+	60,0		ЗДТГ, ХХААГ, Сумдын ХАА-н тасгаг	ХХААГ, Сумдын ХАА-н тасгийн мэргэжилтнүүд
6.3	Сав, баглаа боодол, нэр, шошгыг хэрэглэгчийн хэрэглээнд нийцүүлэх	Стандартад нийцсэн сав баглаа боодолтой болох	+	+			20,0		ХХААГ, АА-н нэгжүүд	ХХААГ

6.4	Бүх сум, байгууллагуудын хүн амын хүнсний ногоо, жимс, жимсгэний хэрэглээг нэмэгдүүлэх, борлуулалтыг төрийн худалдан авалт /боловсрол, эрүүл мэнд, батлан хамгаалах, хууль сахиулах, уул уурхай/-аар худалдан авалтыг дэмжүүлэх бодлого, зохицуулалтын арга хэмжээ авах, худалдаа, үйлчилгээ, аялал жуулчлал, зоогийн газруудад сурталчлах	Эрүүл ахуйн шаардлага хангасан бүтээгдэхүүн хэрэглэнэ.	+	+	+	+	20,0	ЗДТГ, ХХААГ, Сумдын ХАА-н тасаг	ХХААГ, сумын ХАА-н тасаг
6.5	Хүлэмжид тариалагдсан хүнсний ногоо, жимс, жимсгэний борлуулалтыг дэмжих, бүтээгдэхүүнийг сурталчлах зорилгоор "Алтан намар" ургацын баяр, "Хаврын баяр" зэрэг үзэсгэлэн худалдааг аймагт тогтмол зохион байгуулах .	Хүлэмжид тариалагдсан хүнсний ногоо, жимс, жимсгэний борлуулалтыг дэмжиж үзэсгэлэн худалдаануудад тогтмол оролцуулж бүтээгдэхүүнээ сурталчилдаг болсон байна.	+	+	+	+	60,0	ЗДТГ, ХХААГ, Сумдын ХАА-н тасаг	ХХААГ, сумын ХАА-н тасаг
	Нийт санхүүжилт						912,0		



“Хүлэмжийн аж ахуйг хөгжүүлэх” дэд хөтөлбөрийн  
хэрэгжилтийг хангах, хяналт тавих аймгийн салбар зөвлөлийн бүрэлдэхүүн

- Салбар зөвлөлийн дарга: - Аймгийн Засаг даргын Эдийн засаг үйлдвэрлэл дэд бүтэц хариуцсан орлогч
- Гишүүд:
- Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт Хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга
  - Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү Төрийн сангийн хэлтсийн дарга
  - Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, Хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн Хөдөө аж ахуйн асуудал хариуцсан мэргэжилтэн
  - Аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын Үйлдвэр, худалдаа, үйлчилгээний албаны дарга
  - Аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын Үйлдвэр, худалдаа, үйлчилгээний албаны мэргэжилтэн
  - Сумдын Засаг дарга нар
  - Аймгийн агрономичдын холбооны төлөөлөл
  - Мэргэжлийн холбоодуудын төлөөлөл
  - Тариаланч, ногоочдын төлөөлөл
- Нарийн бичгийн дарга: - Аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга